

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

ЭДИЙН ЗАСГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН МӨН ЧАНАР БА ОНОЛ,
ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Г.Мэндхүү*, У.Басбиш**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үгс: сэтгүүл зүй, сэтгүүл зүйн онол, эдийн засгийн мэдээлэл, эдийн засгийн сэтгүүл зүйн судлагдахуун

Дэлхийн аль улсын олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд нийгмийн амьдралын янз бүрийн салбарт өрнөж байгаа үйл явдал, үзэгдлийн тухай цаг алдахгүй шуурхай мэдээлэх замаар үндсэн үүргээ биелүүлдэг. Сэтгүүлчдийн бүтээлд эдийн засгийн сэдэв үлэмж хэмжээний орон зайг эзэлдэг. Өрнөдийн орнуудад эдийн засгийн сэдэвт бүтээлд өргөн цар хүрээтэй судалгаа хийж, онол арга зүйн олон бүтээл гаргажээ. Харин манай орны хувьд сонин хэвлэлд нийтлэгдсэн эдийн засгийн сэдэвт мэдээлэл, радио телевизийн нийтлэл нэвтрүүлэгт эдийн засгийн асуудлыг хэрхэн тусгаж байгаад ажиглалт хийсэн судалгааны бүтээлүүд нэмэгдэх хандлагатай байна. Гэхдээ эдийн засгийн сэтгүүл зүйн онолын суурь судалгааны бүтээл, ном гарын авлага харьцангуй цөөн байна. МУИС-ийн Сэтгүүл зүй, олон

нийтийн харилцааны тэнхимээс 2021 онд эрхлэн гаргасан “Сэтгүүл зүйн үндэс” сурах бичгийн “Сэтгүүл зүйн үйл ажиллагааны түгээмэл чиглэлүүд” хэмээх бие даасан бүлэгт эдийн засгийн сэтгүүл зүйн үндсэн асуудлыг тодорхойлсон байдаг. Харин энэ өгүүлэлд эдийн засгийн сэтгүүл зүйн мөн чанар, ач холбогдлын талаар хөндөж байна.

Эдийн засгийн сэтгүүл зүй үүсэж, хөгжихөд гол түлхэц болсон хөдөлгөгч хүч нь худалдаа юм. Анхны тогтмол хэвлэлд худалдаа арилжааны тухай мэдээ хэвлэгдэж байсан улбаатай. Дундад зууны үеэс бүр эрчимжиж улмаар төрөлжсөн сонин, сэтгүүл баруун Европын орнуудад гарч эхэлсэн байдаг. XVIII зууны хоёрдугаар хагасаас эдийн засаг, санхүү, бизнесийн тухай дагнан бичдэг төрөлжсөн хэвлэлийн тогтолцоо бүрэлдсэн. Дэлхийн улс орнуудын харилцаа өргөжин тэлэх тусам эдийн засгийн сэтгүүл зүйн хүрээ өсөж, улам бүр үндэстэн дамнасан шинжтэй болж байв. XX зуунд хүн төрөлхтний хувьд радио, телевиз өдөр тутмын мэдээлэл авах

гол хэрэгсэл болоход эдийн засгийн тухай сэдэв ч өөрийн байр сууриа эзэлжээ. Зөвхөн эдийн засаг, санхүү, бизнесийн тухай мэдээлэл дамжуулдаг, улс төрчдийн шийдвэр эдийн засагт ямар үр дагавар авч ирж байгааг тусгаж мэдээлдэг радио, телевизийн төрөлжсөн суваг ХХ зууны 80-аад онд байгуулагдсан.

Ийнхүү “Эдийн засгийн сэтгүүл зүй” гэсэн ойлголт аль эртнээс хэрэглэгдэж байгаа боловч ердөө саяхнаас л түүний судлах зүйл, зорилго, үүрэг, арга зүйн тухай судлаач нар анхаарлаа хандуулж эхэлсэн. Эдийн засгийн сэтгүүл зүй бол салбар дундын шинжтэй сэтгүүл зүйн түгээмэл чиглэлийн нэг учраас түүний үзэл баримтлалыг боловсруулахад сэтгүүл зүй, эдийн засаг гэсэн хоёр шинжлэх ухаан харилцан бие биеэ баяжуулж хувь нэмрээ оруулах ёстой юм. Эдийн засгийн сэтгүүл зүйн судалгаанд сэтгүүл зүйн онолчдоос гадна эдийн засагчид ч хувь нэмэр оруулах хэрэгтэй нь зүй ёсны хэрэг юм. Эдийн засгийн сэтгүүл зүйн мөн чанарыг тодорхойлохын тулд сэтгүүл зүйн ерөнхий онол, медиа экономикоос ялгаж зааглах хэрэгтэй. Өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд эдийн засаг, сэтгүүл зүйн харилцан үйлчлэл нь “эдийн засгийн сэтгүүл зүй” гэсэн шинжлэх ухааны судалгааны чиглэлийг бий болгоход хүргэсэн гэж үзэж байна. Эдийн засгийн сэтгүүл зүйн мөн чанарыг тодорхойлохын тулд түүнийг сэтгүүл зүйн ерөнхий онолоос ялгаж, медиа экономик ба сэтгүүл зүйн зааг ялгааг гаргах шаардлагатай. Эдийн засгийн

онолын нэгэн адил сэтгүүл зүйн онол нь эрчимтэй хөгжиж байгаа шинжлэх ухаан юм. Ер нь сэтгүүл зүй нь бүхэлдээ нийгэм эдийн засгийн тогтолцоонд нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа нийгэм-практикийн үйл ажиллагаа юм. Иймд ойлголтоо тодорхой болгож, шинжлэх ухаан ба практик үйл ажиллагааных нь хувьд сэтгүүл зүй ба эдийн засгийн харилцан үйлчлэлийн арга замыг тогтоох шаардлага тулгарна.

“Сэтгүүл зүй” гэдэг нэр томъёог “Сэтгүүл зүйн тайлбар толь” номд дараах байдлаар тодорхойлжээ. “Сэтгүүл зүй бол цаг үеийн чухал мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлбарлах болон түүнийг техник хэрэгслүүдийн тусламжтайгаар олон түмэнд тогтмол түгээх зорилго бүхий нийгмийн үйл ажиллагаа мөн” (Зулькафиль, 2018). Судлаач М.Зулькафиль сэтгүүл зүй бол олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тогтолцоо ба олон нийтийн мэдээллийн үйл ажиллагаа мөн бөгөөд нийгмийн онцгой институт, үйл ажиллагааны тогтолцоо, мэргэжлүүдийн төвлөрөл, уран бүтээлийн тогтолцоо, мэдээлэл дамжуулах сувгуудын иж бүрдэл гэж үзсэн байдаг (Зулькафиль, 2014). Энэ бүхнээс үзвэл сэтгүүл зүй бол нэгдүгээрт, олон нийтийн мэдээллийн ба үйлдвэрлэлийн үйл ажиллагаа; хоёрдугаарт, медиа систем (ОНМХ-ийн систем) ба медиа үйлдвэрлэл; гуравдугаарт, уран бүтээлийн тогтолцоо; дөрөвдүгээрт, шинжлэх ухааны мэдлэгийн салбар гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Хэрэв сэтгүүл зүйг олон нийтийн мэдээллийн үйл ажиллагаа ба үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэж авч үзэж байгаа бол эдийн засгийн сэтгүүл зүй нь тухайн салбартай холбоотой цаг үеийн чухал мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлбарлах болон түүнийг техник хэрэгслүүдийн тусламжтайгаар (сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим хэвлэл зэргээр дамжуулан) олон нийтэд тодорхой давтамжтайгаар түгээх зорилго бүхий нийгмийн үйл ажиллагаа мөн. Сэтгүүл зүйн энэ чиглэлийн гол объект нь эдийн засгийн мэдээлэл юм.

Эдийн засгийн мэдээллийг бэлтгэж түгээн дэлгэрүүлэгч нь янз бүрийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бий болгодог. Эдийн засгийн сэтгүүл зүйн үүргүүдийг биелүүлж байгаа тохиолдолд тухай ОНМХ-үүд нийгмийн тогтолцоо (медиа систем) бий болгож төлөвшинө. Эсвэл ОНМХ-ийг зах зээлийн эдийн засгийн нэг оролцогч (субъект) ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрхлэн явуулагч гэж авч үзвэл медиа үйлдвэрүүдийн тогтолцоог бий болгоно.

Эдийн засгийн сэтгүүл зүйн мөн чанарт дүн шинжилгээ хийхэд хоёр дахь хүчин зүйл нь эхнийхтэйгээ нягт холбоотой—медиа үйлдвэрүүдийн тогтолцооноос медиа системийн үүргийн ялгаа тодордог. Эдийн засгийн сэтгүүл зүйд медиа систем нь эдийн засгийн мэдээллийг урсгал байдлаар зохион байгуулахад дайчлагддаг. Ингэснээр, ОНМХ-ийн тогтол-

цоо нь нийгмийн үүргийг биелүүлдэг. Энэ үүргийг биелүүлэх нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай нягт уялдаатай. ОНМХ-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа (ОНМХ-ийн системийг бус, харин медиа үйлдвэрүүдийн систем үүсгэгч медиа үйлдвэрлэгчийн үүрэгтэй оролцогч) нь санхүүгийн, баялгийн, хүний нөөцийн урсгал зохион байгуулахтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, медиа үйлдвэрийн тогтолцооны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны утга учир нь эдийн засгийн мэдээллийг түгээх эдийн засгийн сэтгүүл зүйн эцсийн зорилгод хүрэхэд байдаг. Ийм үйл ажиллагаа нь эдийн засгийн мэдээллийг ашиглахыг илэрхийлдэг боловч, хэрэв нийгмийн үүргийг медиа систем биелүүлж байгаа тохиолдолд эдийн засгийн мэдээлэл “гаднын” шинж чанартай байдаг нь хүлээн авагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн (эдийн засгийн медиа бүтээгдэхүүн) болно. Энэ тохиолдолд эдийн засгийн мэдээлэл нь хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд боловсруулагдаж үйлдвэрлэгдсэн бол “бараа, бүтээгдэхүүн” болно. Харин төрийн өмчийн хэвлэл мэдээллийн байгууллага үйлдвэрлэгч нь бол нийтийн ашиг тусын тулд бүтээгдсэн гэж тайлбарлаж болно. Эдийн засгийн мэдээллийн гол хэрэглэгч нь хувь хүн, өргөн олон түмэн, хуулийн этгээд юм.

Медиа байгууллагууд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхдээ “дотоод” шинж чанартай, зөвхөн медиа бизнесийн сонирхлыг татсан

эдийн засгийн мэдээллийг ашигладаг. Мэдээжийн хэрэг, медиа системийн эцсийн бүтээгдэхүүн болдог эдийн засгийн мэдээлэл, эдийн засгийн дотоод нөөц, үйлдвэрлэлийн хүчин зүйл болдог эдийн засгийн мэдээлэл нь нэг цэгт давхацдаг. (жишээ нь, валютын ханшийн тухай мэдээлэл нь хүлээн авагчдад медиа бүтээгдэхүүн болохын зэрэгцээ медиа үйлдвэрүүдийн эдийн засгийн төлөв байдалд нөлөөлнө.)

Эдийн

засгийн сэтгүүл зүйн мөн чанарт дүн шинжилгээ хийхэд гурав дахь хүчин зүйл нь уран бүтээлийн тогтолцооны судлах явдал юм. Ингэхдээ эдийн засгийн сэтгүүл зүйг тодорхой бүлгийн хүлээн авагчдын оюуны эрэлт хэрэгцээг хангадаг сэтгүүл зүйн бусад чиглэлүүдээс ялгаж салгаж авч үзэх хэрэгтэй.

АНУ болон Баруун Европын орнуудад “Бизнес сэтгүүл зүй” (Business journalism), “Санхүүгийн сэтгүүл зүй” (Financial journalism), Орос болон Зүүн Европын орнуудад “Ажил хэргийн сэтгүүл зүй” (“Деловая журналистика”), “Байгууллагын сэтгүүл зүй” (Корпоративная журналистика) гэх мэт үг

хэллэг өргөн ашиглагддаг. Эдгээр нэр томъёонууд нь эдийн засгийн сэтгүүл зүйг бүрдүүлэгч нэг хэсэг юм. Иймд “Эдийн засгийн сэтгүүл зүй” (орос. Экономическая журналистика/ анг. Economy journalism) гэдэг ерөнхий нэр томъёог ашиглах нь илүү оновчтой юм. Учир нь эдийн засаг гэдэг ерөнхий ойлголтод банк санхүү, түүхий эдийн бирж, хөрөнгийн бирж, үндэстэн дамнасан корпорац, компаниудын үйл ажиллагаа, үйлдвэрлэл, худалдааны хэл-

цэл зэрэг өргөн хүрээний асуудал багтааж болно. Эдийн засгийн янз бүрийн салбар, чиглэлтэй холбоотой мэдээлэл дурын ямар ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгддэг. АНУ, ОХУ, Европын улс орнууд, санхүүгийн зах зээл амжилттай хөгжсөн Ази тивийн орнуудын сэтгүүлч бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт нь санхүү-эдийн засаг, ху-

далдаа, арилжааны тухай хэрхэн зөв, оновчтой мэдээлэх тухай тусгай хичээл ордог гэдгийг ч цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

Уран бүтээлийн тогтолцооны хувьд эдийн засгийн сэтгүүл зүй нь нэг талаас, “эдийн засгийн сэдвээр

«

Уран бүтээлийн тогтолцооны хувьд эдийн засгийн сэтгүүл зүй нь нэг талаас, “эдийн засгийн сэдвээр төрөлжсөн ОНМХ-ийн” агуулгыг бүрдүүлдэг бүтээлүүдээс; нөгөө талаас дурын ямар ч ОНМХ-д нийтлэгдэж байгаа эдийн засгийн сэдвээр бичсэн сэтгүүлчийн бүтээлээс бүрдэнэ. Энэ тохиолдолд эдийн засгийн сэтгүүл зүй нь нийгэм, эдийн засаг, соёлын ба амьдралын бусад салбартай холбоотой дэд бүтэц үүсгэдэг өөрийн гэсэн өвөрмөц мета систем болж байна.

»

төрөлжсөн ОНМХ-ийн” агуулгыг бүрдүүлдэг бүтээлүүдээс; нөгөө талаас дурын ямар ч ОНМХ-д нийтлэгдэж байгаа эдийн засгийн сэдвээр бичсэн сэтгүүлчийн бүтээлээс бүрдэнэ. Энэ тохиолдолд эдийн засгийн сэтгүүл зүй нь нийгэм, эдийн засаг, соёлын ба амьдралын бусад салбартай холбоотой дэд бүтэц үүсгэдэг өөрийн гэсэн өвөрмөц мета систем болж байна. Тухайн сэтгүүлчийн бүтээл эдийн засгийн асуудалтай шууд холбоогүй байсан ч янз бүрийн нөхцөл байдал хувь хүний биеэ авч явах төлөв байдлыг тайлбарлах үндэслэл нь эдийн засгийн хүчин зүйлийн нөлөө болдог. Энэ бол эдийн засгийн сэтгүүл зүйн оролцоо юм. Энэ утгаараа эдийн засаг тодорхой үзэл суртал болж байна. Ийнхүү бид эдийн засгийн сэтгүүл зүйг практик үйл ажиллагаа, медиа систем ба медиа үйлдвэрийн тогтолцоо, уран бүтээлийн тогтолцоо гэж тодорхойллоо.

Бидний үзэж байгаагаар, эдийн засгийн сэтгүүл зүй нь мэдлэгийн салбар гэж ярьж болохоор хэмжээний хөгжлийн түвшинд байна. Энэ талаас нь авч үзвэл, эдийн засгийн сэтгүүл зүйг олон нийтийн эдийн засгийн харилцааны зүй тогтлыг судалдаг, өөрийн арга зүй, нэр томъёо, объект, судлах зүйлтэй шинжлэх ухааны салбар гэж тодорхойлж болох юм. Түүнчлэн, практикт эдийн засгийн харилцааны аргачлалыг боловсруулах арга зүйн суурь нь болж, эдийн засгийн сэтгүүл зүйн практик ажиллагааны зарчмыг тодорхойлох үндэс болох ёстой юм. Эдийн засгийн сэтгүүл

зүйн онолын арга зүйн үндэс нь сэтгүүл зүйн онол, харилцааны олон, эдийн засгийн онол юм. Эдийн засгийн сэтгүүл зүйн арга зүйн үндэс нь сэтгүүл зүйн онол, харилцааны онол, эдийн засгийн онол юм. Эдийн засгийн сэтгүүл зүйн судлах зүйл нь олон нийтийн эдийн засгийн харилцаа болдог бөгөөд эдийн засгийн мэдээллийг хэвлэл, радио, телевиз, кино, дуу дүрс бичлэг, интернэт орон зайд системтэйгээр түгээхдээ эдийн засгийн сэтгэлгээг төлөвшүүлэх, газар зүйн тодорхой хил хязгаар дотор эдийн засгийн нэгдмэл орон зайг үүсгэх, нийгмийн хэсэг бүлгийн үнэт зүйлс, үзэл бодол, хүлээлтэд үзэл суртлын болон эдийн засгийн тодорхой нөлөөг үзүүлэх зорилготой байдаг. Эдийн засгийн сэтгүүл зүйн объект нь олон нийтийн эдийн засгийн харилцааг түгээгч хэвлэл, радио, телевиз, кино, дуу дүрс бичлэг, янз бүрийн хэв маягийн “шинэ” ОНМХ юм. Харин эдийн засгийн сэтгүүл зүйг практик үйл ажиллагаа гэж авч үзвэл, эдийн засгийн сэтгүүл зүй бол олон нийтийн мэдээлэл-харилцааны үйл ажиллагаа болох бөгөөд судлах зүйл нь эдийн засгийн салбар бүрэн цогцоороо, харин объект нь дэлхийн болон манай эх орны аж ахуй, үйлдвэрлэлийн салбарууд, нийгмийн институт, дурын хувь хүн зэрэг болно.

XX зууны 90-ээд оны эхэн үед Монголын олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд зах зээлийн эдийн засгийн тогтолцоог Монголд хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа гэдэг байр суурийг баримталж, олон

түмнийг үүнд итгүүлж байлаа. Харин тухайн үед зах зээлийн эдийн засгийн тулгамдсан асуудал, сөрөг талын тухай нийтлэл, нэвтрүүлэг бараг гараагүй юм. Өнөө үед эдийн засгийн сэдвээр бичигдсэн сэтгүүл зүйн бүтээлүүд нь үзэл суртлын, суртал ухуулгын шинжтэй байхаа больсон бөгөөд мэдээллийн үүргийг хэрэгжүүлж, зах зээлийн эдийн засгийн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болж байна. Өнөөдөр эдийн засгийн сэдэвт сэтгүүл зүйн бүтээлүүд өөрийн зохих байр сууриа эзэлж, бичлэгийн төрөл зүйл, шинж төлөв нь тодорхойлогджээ.

Эдийн засгийн сэтгүүл зүйн бүтээлийн тогтолцоо зөвхөн төрөлжсөн ОНМХ-ийн хүрээгээр хязгаарлагдахгүй гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Төрөлжсөн ОНМХ (бизнесийн төрөлжсөн сонин, санхүү банк-ны салбарын сэтгүүл г.м) тодорхой хүрээний хүмүүст зориулагдаж хаяглагдсан байдгаараа ялгардаг. Ийм хэвлэлүүд нь хэрэглээ сонирхол нь дан эдийн засгийн мэдээллээр хязгаарлагдаагүй боловч анхаарал, цаг хугацаагаар хязгаарлагдсан шийдвэр гаргагч нарт зориулагдсан байдаг. Иймээс ажил хэрэгч хүмүүст зориулсан хэвлэлд эдийн засгийн мэдээллээс гадна улс төрөөс эхлээд зугаа цэнгээний салбар хүртэлх амьдралын бусад салбарын тухай мэдээлэл нийтлэгддэг. Гэвч ийм хэрэглэгчдийн хүрээ их биш. Үүний зэрэгцээ аль нэгэн төрийн болон хувийн аж ахуйн нэгжид хөдөлмөрлөдөг жирийн ажилчид ч гэсэн эдийн засгийн мэдээлэл авах хэрэгцээ

шаардлагатай байдаг. Эдийн засгийн сэтгүүл зүй нь ийм хүмүүст өөрсдийн мөнгөний зарцуулалт, өрхийн төсвөө тооцоолж төлөвлөхөд нь тусалдаг. Эдийн засгийн сэтгүүл зүй шийдвэр гаргахад тусалдаг уу? гэсэн асуултыг дотор бүр нарийвчлан задалж гурван бүлэгт хувааж болно.

Нэгдүгээрт, макро эдийн засгийн: инфляцын төвшний хэтийн төлөв, үүнтэй холбоотойгоор хуримтлуулах уу, эсвэл хэрэглээнд тулгуурлах уу, хуримтлалаа ямар хэлбэрээр хадгалах вэ, эдийн засгийн мөчлөг уналт, өсөлтийн ямар үед орсон байна? Ажилгүйдлийн төвшин, түүний үр дагавар, янз бүрийн салбарт хөдөлмөрийн хөлс ямар байна вэ, улс орон, бүс нутгийн хэмжээнд хөдөлмөрийн хөлс жигд байна уу? Нийгмийн халамж хамгааллын баталгаа ямар байна? Төрөөс эдийн засгийн ямар бодлого хэрэгжүүлж байна? Нийгэмд шударга ёс байна уу?

Хоёрдугаарт, микро эдийн засгийн: аль салбарт хөдөлмөрлөх вэ? Хөдөлмөрийн зах зээлд ямар ажил мэргэжил эрэлттэй байна вэ? Ойрын ирээдүйд ямар мэргэжил эрэлттэй болох вэ? Хөлсний ажил хийх үү эсвэл өөрөө бие даан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нь дээр үү? Оршин амьдарч байгаа бүс нутаг нь хэр зэрэг ирээдүйтэй вэ? Орон нутгийн засаг захиргааны байгууллагын (эсвэл ажиллаж байгаа салбарын бодлого тодорхойлогч нар, ажиллаж байгаа компанийн удирдлагын) нийгэм эдийн засгийн бодлого юунд чиглэгдэж байна? г.м.

Гуравдугаарт, хэрэглэгчдийн: хэзээ, хаанаас юуг худалдан авах уу? Хэрэглэж байгаа бүтээгдэхүүний чанар, борлуулалтын цэг, үнэ, хямдрал, жижиглэнгийн болон бөөнөөр худалдах үнэ г.м.

Эдийн засгийн мэдээлэл эдгээр болон бусад асуултын хариулыг олж шийдвэр гаргахад тусалдаг учраас төрөлжсөн болон олон нийтэд зориулсан хэвлэл гэж хоёр хуваагдахад хүрдэг. Гэхдээ төрөлжсөн сонин, сэтгүүл, радио, телевизэд ажиллаж байгаа сэтгүүлчийн мэдлэг, хүлээн авагчдын боловсролын түвшин, хүрээ ялгаатай байдаг гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Эдийн засгийн мэдээлэл нь төрөлжсөн ажил хэрэгч хүмүүст зориулсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бүх нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн аль алинд нь байх ёстой. Зөвхөн сэтгүүлчдийн мэдлэг, хүлээн авагчдын өмнө тулгарч байгаа асуудлын бүтэц нь өөр байж болно. Зар сурталчилгаа ба олон нийттэй харилцах үйл ажиллагаанаас юугаараа өөр вэ гэдгийг эдийн засгийн сэтгүүл зүй ялгаж салгах боломж олгодог байна.

Сэтгүүл зүйн шинжлэх ухааны нэг салбар, олон нийтийн мэдээллийн практик үйл ажиллагаа болохын хувьд эдийн засгийн сэтгүүл зүй нь онолын судалгаа шаарддаг. Мөн хүний нөөцийн асуудал ч тулгардаг. Эдийн засгийн алыг чадавхжуулах, мэргэшсэн сэтгүүлчдийг бэлтгэх, давтан бэлтгэх шаардлагатай байна (Энхбат, 2019).

“Эдийн засгийн сэтгүүлч” бол эдийн засгийн онол (эдийн засгийн асуудлуудын тухай ерөнхий төсөөлөлтэй болохын тулд), дэлхийн эдийн засгийн тухай мэдлэг, эдийн засгийн нэр томъёог мэддэг байх шаардлагатай. Ерөнхий мэдээлэл дамжуулдаг ОНМХ-д эдийн эдийн засгийн асуудлаар бичдэг сэтгүүлчийг, эдийн засгийн аль нэг салбарын тухай дагнан мэдээлэл түгээдэг төрөлжсөн хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг сэтгүүлчтэй харьцуулахад тавигдах шаардлага ч ялгаатай гэдгийг хялбархан анзаарч болно. Эдийн засгийн аль нэг салбарын тухай дагнан мэдээлэл түгээдэг хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчээс илүү ахисан шатны мэдлэгтэй байхыг шаарддаг. Үүнд нийцүүлэн ирээдүйн сэтгүүлч дэлхийн, үндэсний, салбарын, орон нутгийн эдийн засгийн тухай гүнзгий мэдлэг авсан байх ёстой. Түүнээс гадна, зар сурталчилгаа, олон нийттэй харилцах тухай мэдлэг ч хэрэг болно. Дээр нэр дурдсан мэдлэг чадварууд бол “эдийн засгийн сэтгүүлч” төлөвшүүлэх үндэс болж байна. Олон талт мэдлэгтэй байх хэрэгтэй гэдэг сэтгүүлчийн боловсрол, мэдлэгийн ерөнхий “дүр зураг”-аас гадна ирээдүйн эдийн засгийн сэтгүүлчдэд тусгай мэргэшсэн мэдлэг шаардлагатай гэдэг нь илэрхий. Эдийн засгийн сэдвээр дагнан бүтээл туурвих сонирхолтой байгаа ирээдүйн сэтгүүлчдийн хувьд мэргэшүүлэн судлах хичээл нь “эдийн засгийн сэтгүүл зүй” байх нь илэрхий. Эдийн засгийн сэтгүүл зүй бол сэтгүүл зүйн

онол, эдийн засгийн онол, нийгмийн сэтгэл судлал, эдийг засгийн социологи зэрэг олон шинжлэх ухааны конвергенцийн үр дүн юм. Эдийн засгийн онолыг төгс боловсруулахын тулд дээр нэр дурдсан салбарын эрдэмтдийн харилцан үйл ажиллагаа зайлшгүй. Ийм харилцан үйл ажиллагааны суурь нь сэтгүүл зүйн онол болно. Судалгааны чухал сэдэв нь “олон түмний эдийн засгийн харилцааны онцлог, зорилго, зорилт, эдийн засгийн сэтгүүл зүйн үүрэг, эдийн засгийн сэтгүүл зүйн зарчим, иргэний нийгэмд эдийн засгийн сэтгүүл зүйн оролцоо, эдийн засгийн сэтгүүл зүйн гарал үүсэл (генезис), медиа системээс эдийн засгийн сэтгүүл зүйг тодотгож түүний онцлог, хэв шинжийг гаргах, ОНМХ-д эдийн засгийн асуудлыг тусгаж байгааг судлах зэрэг болно. Нийгэм-эдийн засгийн системийн үйл ажиллагаанд эдийн засгийн сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг чухал ач холбогдолтой тул онолын энэ чиглэл хөгжих нь дамжиггүй. Сэтгүүл зүйн онолын судлаачид эдийн засгийн асуудлаар мэдлэг дутмаг байх, эдийн засгийн онолчид сэтгүүл зүйн онолын тухай мэдлэг дутмаг байх нь бэрхшээл үүсгэж болзошгүй юм. Мөн энэ нөхцөл байдал их дээд сургуульд “Эдийн засгийн сэтгүүл зүй” хичээлийг чанартай заахад бэрхшээл болно. Эдийн засгийн болон сэтгүүл зүйн шинжлэх ухааны судлаачдын хамтын ажиллагаа энэ чиглэлийн хөгжилд түлхэц болж

чадна. Сэтгүүл зүйн онол нь эдийн засгийн асуудлыг хэрхэн олон түмэнд ойлгомжтой мэдээлэх вэ? гэдэг асуултад хариулт өгөх бол, эдийн засгийн онол, эдийн засгийн социологи, эдийн засгийн сэтгэл зүй нь эдийн засгийн сэтгүүл зүйн асуудлуудыг боловсруулахад хувь нэмэр болно.

Эшлэл

1. Зулькафиль М. 2018. Сэтгүүл зүйн тайлбар толь. х.219
2. Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. х.21
3. Энхбат Ч. 2019. Эдийн засгийн сэтгүүл зүйн тулгамдсан зарим асуудал, боловсронгуй болгох арга зам. “Сэтгүүл зүй” сэтгүүл. №20 (524). х.70

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б., Зулькафиль М. 2021. Сэтгүүл зүйн үндэс. УБ.
2. Ворошилов. В.В. 2004. Журналистика. Спб.
3. Зулькафиль М. 2018. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
4. Мельник Г., Виноградова С.2010. Деловая журналистика. Спб.
5. Сэтгүүл зүй сэтгүүл. 2019. №20 (524)

Summary

The article describes essence and problems of economic journalism. The author points out economic journalism from the general theory of journalism, enumerates aspects of studying journalism, gives definition to economic journalism and defines subject, object of economic journalism. Also, author listed the competences of an economic journalist.